

## **9**

### **ЭДИЙН ЗАСГИЙН АНГЛИ ХЭЛ ЗААХ АРГЫН ЗАРИМ АСУУДАЛД**

#### **Б.Энхбаяр**

1990-ээд оноос Монгол улсад ардчилсан хувьсгал ялж Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээр тус улсын гадаад харилцаанд үндсэн эргэлт гарч зөвхөн хөрш хоёр улс болон хуучин социалист системийн гэгдэх хэдхэн орноор хязгаарлагдахгүй, зах зээл хөгжсөн дэлхийн өндер хөгжилтэй улс орнуудтай ч улс төр, эдийн засаг, бизнес соёлын харилцааг төр улсын хэмжээнд төдийгүй пүүс, компани, үйлдвэр, аж ахуй, соёл, олон нийтийн байгууллага, хувь хүмүүс зэрэг нийгмийн харилцааны бүх салбарт хөгжүүлж эхэлснээр англи хэл сурх явдал нэн тулгамдсан зорилт болон тавигдаж хүүхэд, хөгшидгүй бүх нийтээрээ англи хэлийг шамдан суралцах болсон билээ. Иймд англи хэлийг нийт хүмүүст богино хугацаанд хэрхэн үр дүнтэй сургахав, тэр тусмаа төрөл бүрийн мэргэжлийн салбарт ажиллаж буй хүмүүсийг тухайн мэргэжлээрээ дэлхийн түвшнээс хоцрохгүй, шинэ соргог мэдээ мэдээллийг цаг тухайд нь авах боломжоор хангахын тулд англи хэлийг яаж эзэмшүүлэх вэ гэдэг асуудал англи хэлний нийт багш нар, хэл судлаачид, заах аргачдын өмнө зайлшгүй бүтээлчээр хандах зорилт болон тавигдаж байна. Ийм учраас бид өнөөдөр мэргэжлийн англи хэл тухайлбал эдийн засгийн англи хэлийг хэдийд, ямар хугацаанд яаж сургахав гэсэн асуудлыг сонирхон авч үзэж, өнөөгийн англи хэл зааж буй байдал, явц, туршлага дээрээ тулгуурлан цаашид ямар зорилт тавих вэ гэдэг асуудлыг дэвшүүлэн тавьж буй болно.

#### **Мэргэжлийн хэл заах онолын асуудалд**

Мэргэжлийн хэлийг гадаад хэл сурх яж эхний шатанд сургахын хэл шинжлэл болон заах аргын үндсийг судлах нь чухал юм. Учир нь энэ үед (шатанд) мэргэжлийн хэлийг цаашид суралцахын хэлний үндэс тавигддаг бөгөөд мэргэжлийн хэлийг заах сургалт зохион байгуулалтын асуудлыг эхнээс нь зөв шийдвэрлэснээр цаашид мэргэжлээ болоод хэлийг үр дүнтэй эзэмшихийн үндэс тавигдана.

Мэргэжлийн хэлийг амжилттай сургах эх үндэс нь мэргэжлийн хичээлтэй нь зэрэгцүүлэн холбох явдал юм. Өөрөөр хэлбэл мэргэжлийн хэлийг заахдаа тухайн мэргэжлийн салбарын мэдлэг олгохуйц материал дээр үндэслэх нь чухал ач холбогдолтой. Оросын судлаач Е.И.Мотинагийн үзэж байгаагаар “Өөр салбарын буюу ерөнхий сэдэв дээр сууринж мэргэжлийн хэл эзэмшүүлэх гэсэн анхны оролдлого нааштай үр дүн өгөөгүй байна. Тиймээс оюутныг мэргэжлийн хэлэнд сургахын тулд хэл сургах хэрэглэгдэхүүн материалыг тухайн судлах салбарт нь тохируулж өгөх явдал чухал ач холбогдолтой” байна<sup>1</sup>.

Мэргэжлийн хэлийг эзэмшсэнээр тухайн мэргэжлээрээ мэдлэг олж аваад зогсохгүй мэргэжлийн хэлээрээ харилцаж сурна. Мэргэжлийн хэл сурх үйл явц салбар факультет бүрийн сургалттай нягт зохицдолгоо, уялдаа холбоотой байх ёстай. Мэргэжлийн хэл нь тухайн мэргэжил бүрийн онцлогоос хамаарч ялгаатай байх боловч, хэл зүйн ерөнхий нэгдмэл зарчмаас шалтгаалсан ерөнхий зүй тогтоо алдахгүй байх ёстай. Чухамхүү ямар салбарт хэлний ямар харилцаа түлхүү хэрэглэгдэх вэ? Харилцааны зорилго үндэс юу вэ? гэдгээс хэлний харилцааны ямар хэрэгсэлийг сонгож авах нь шалтгаална.


Мэргэжлийн хэлний онцлог нь эхний шатандаа багшийн зүгээс ч сургчийн зүгээс ч ихэвчлэн монолог буюу хүүрнэх яриаг шаарддаг. Оюутан тухайн мэргэжлээр авсан мэдлэгээ зөвхөн оюун ухаандаа хуримтлуулж хадгалах биш, харин түүний харилцааны янз бүрийн нөхцөлд хэрэгжүүлэх шаардлагатай болдог учраас мэргэжлийн хэл судлахад хэлний зөвхөн хүлээн авах төдийгүй бүтээлчээр хэрэгжүүлэх бүх л чадвар дадал адилхан чухал үүрэгтэй (Speaking, listening, writing and reading).

Тухайн салбарын мэргэжилтэн нь өөрийн мэргэжлийн дагуу ном хэвлэл үншиж ашиглах шаардлагатай болно. Иймд үнших чадвар, үншсанаа ойлгох явдал, өөрийгөө болон мэргэжлээ танилцуулж, мэргэжлээрээ санаа бодлоо солилцоход, ярих чадвар, тэр тусмаа хүүрнэн ярих дадал мэргэжлийн хэлэнд чухал үүрэгтэй. Хүүрнэх ярих чадварт сургах гол хэрэгсэл нь текст бөгөөд энэ нь утга төгөлдөр ярианы үндсэн нэгж юм. Сургалтын ямар шатанд байгаагаас шалтгаалж хэлний янз бүрийн чадварыг харилцан хамааралтай эзэмшүүлэх ёстай бөгөөд эдгээр төрлөөс мэргэжлийн тексттэй ажиллах явдал үндсэн төрөл хэвээр байна. Хамгийн гол нь мэргэжлийн хэлээ бүрэн эзэмших үүний тулд юуны өмнө толь бичиг хэрэглэхгүйгээр мэргэжлийн холбогдолтой текст ном зохиолыг үншиж ойлгодог, өөрийн мэргэжилтэй холбоотой аливаа асуудлаар мэдээлэл хийдэг, харилцан ярилцдаг чадвар эзэмшүүлэх явдал чухал юм. Ямар ч хэлний хичээлийг оюутны үгсийн санг нэмэгдүүлж, толь бичиггүйгээр текст үншиж орчуулдаг, ярианы хэлний чадвар эзэмшүүлэх хэрэгсэл болгож болно. Энэ нь зөвхөн мэргэжлийн тексттээ зөв сонгож авах болон хичээлээ явуулах заах аргатай холбоотой нь мэдээж юм. Текстэн дээр ажиллахад оюутнууд тухайн текстийг зөвхөн механикаар цээжлээд бие дааж өгүүлбэр зохиох, өөрийн үзэл бодол санаагаа илэрхийлэх чадвар

<sup>1</sup> Е.И.Мотина “Язык и специальность” М. 1988.

эзэмшдэггүй. Түүний оронд оюутнаар үншсан текстийг нь утгаар нь хэдэн хэсэг болгож гарчиг өгүүлэх, үгүй бол текстийн талаар товч төлөвлөгөө гаргуулах зэргээр тухайн текстийг толь бичиггүйгээр ойлгоод зогсохгүй гадаад хэлээр сэтгэхийн эхлэлийг тавьж өгнө. Энэ ажлын явцад оюутнууд бие биеэсээ богино хугацаанд хичээл дээрээ шинэ үг хэллэг сурх боломж олгодог. Ингэснээр дараагийн текст дээр ажиллахад хугацаа бага шаардгажд гэрийн даалгаварт өөр янз бүрийн дасгал өгөх боломж гарна. Мөн текстэнд асуулт тавиулах, ижил төстэй сэдвээр зохион бичлэг бичүүлж яриулах зэрэг нь хэлний орчин байхгүй нөхцөлд ярих чадварыг сайжруулах ач холбогдолтой.

Англи хэлний хичээлийг эдийн засгийн оюутнуудад заадаг өөрийн арга барил болон оюутнуудад тохиолддог бэрхшээл хүндрэлийн зарим асуудлыг тогтох үзье. Аливаа гадаад хэлийг төрөлх хэлтэйгээ харьцуулж судлах нь ухамсартай сургалтын нэг хэлбэр учир өөрийн заах аргадаа ч харьцуулалтын аргыг хэрэглэдэг. Англи хэл эхлэн суралцаж буй манай оюутнуудын хувьд нийтлэг тохиолддог бэрхшээлтэй зүйл нь англи хэлний өгүүлбэрийн бүтэц, артикль буюу ялгац гишүүн, бичлэг дуудлагын ялгаатай байдлаас шалтгаалж зөв үнших, үйл үгийн цаг зэрэг юм. Эдгээр үг зүй болон дүрмийн асуудлыг богино хугацаанд хялбархан ойлгуулах хамгийн сайн арга нь харьцуулалт билээ. Жишээ нь англи монгол хэлний өгүүлбэрийн бүтэц, өгүүлбэр дэх үгсийн дараалал харилцан адилгүйгээс оюутнуудад англиар үншихадаа үгс хоорондын харилцаа хамаарлыг ойлгохгүй байх бэрхшээл тохиолддог. Иймд англи хэлний өгүүлбэрийн бүтцийг монгол хэлний өгүүлбэр зүйн бүтэцтэй харьцуулж тайлбарладаг.



(S) буюу өгүүлбэр (NP) noun phrase нэр үгийн аймаг болон (VP) verb phrase үйл үгийн аймагаас бүрддэг. (NP) нь (D) determiner - тодотгол болон (N) нэр үгээс, (VP) үйл үгсийн аймаг нь (V) үйл үг болон өөр нэгэн (NP) нэр үгийн аймагаас тогтоно. Англи хэлний өгүүлбэр зүйн үндсэн бүтэц энэ бөгөөд үүнийг сайтар ойлгуулах хэрэгтэй. Бас өөр нэг жишээ авч үзье. Хамаатуулах төлөөний үг англи хэлэнд өргөн хэрэглэгдэг бөгөөд үүнийг монгол хэлэнд хамаатуулахын тийн ялгалын -аа, -оо,

ээ, ёө дагавраар илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл заавал миний, чиний, түүний, бидний гэх мэтээр орчуулах албагүй.

Жишээ нь:

He washed his face

Тэр нүүрээ угаалаа

I do my homework

Би гэрийн даалгавараа хийдэг

Би даалгавраа хийдэг Г.М.

Мөн англи хэлний түйлын хамуутуулах төлөөний үгс-mine, yours, ours-зэргийг монгол оюутнуудад ойлгуулах нь орос хэлтэй харьцуулахад хялбар байдаг. Учир нь эдгээр үгс нь монгол хэлний минийх, чинийх, танайх зэрэг хамаатуулах төлөөний үгсүүдтэй шууд тохирдог. Ямар ч монгол хүн "минийх үзэг, чинийх ном, танайх байшин" гэж ярихгүй нь мэдээж болохоор ардаа нэр үг шаарддаггүй англи хэлний эдгээр төлөөний үгийг манай оюутнууд амархан ойлгодог.

Мөн манай оюутнуудын хувьд англи хэлний үйл үгийн цагийг ойлгоход бэрхшээл учирдаг. Учир нь тэд англи хэлний үг маш олон цагтай ойлгоход төвөгтэй гэж үздэг. Гэтэл эдгээр цагууд хэл шинжлэлийн үүднээс нарийн хувааж авч үзээгүй боловч бүгд монгол хэлэнд байдаг. Үүнийг нэг жишээн дээр авч тайлбарлахад л ойлгомжтой. Жишээ нь: явж байна, явсаар байна, явдаг, явчихлаа, явсан, явлаа, явчихсан байсан гэх мэт үйл үгүүдийг самбарт бичээд хоорондоо утга болон цагийн хувьд ижил үү ялгаатай юу гэдгийг л ойлгуулахад англи хэлний үйл үгийн олон цаг гэдгийн учрыг ойлгодог. Одоо дуусч буй цаг (The Present Perfect Tense) нь ойлгоход нэлзээд түвэгтэй байдаг. Учир нь үйл явдал болоод өнгөрчихсөн байдаг учраас энгийн өнгөрсөн цагтай (the Past simple) эндүүрдэг. Гэтэл англи хэлэнд үйл явдал дууссан цаг нь одоо цагаас холдоогүй учир одоо цагт хамааруулж үздэг байна. Тэгэхээр одоо дуусч буй цаг нь нэг талаас өнгөрсөн цагт эхлээд одоо дуусаж байгаа буюу саяхан болж өнгөрсөн үйл явдлыг илэрхийлдэг.

Одоо дуусч буй цаг нь одоо цагтай холбоотой байдаг бол энгийн өнгөрсөн цагт ийм холбоо байхгүй. Одоо дуусч буй цагийн энэ утгыг монгол хэлний үйл үгийн "чихлаа, чихлээ" төгсгөлөөр илэрхийлж болно. Жишээ нь: Явчихлаа, явлаа гэдэг хоёр үгийг аваад үзэхэд хэдийгээр хоёулаа болоод өнгөрсөн үйл явдал боловч цагийн ялгаа андашгүй байна. Явчихлаа гэдэг үгэнд дөнгөж сая явлаа гэсэн санаа илт харагдаж байна. Түүнээс гадна энгийн өнгөрсөн цагийн өгүүлбэрт цаг хугацаа тодорхой заадаг бөгөөд хэзээ? гэсэн асуулт тавьж болдог. Гэтэл одоо дуусч буй цагаар илэрсэн өгүүлбэрт тухайн үйл явдлыг болсон уу, үгүй юу гэдгийг сонирхохос биш хэзээ? Гэсэн асуулт тавьж болдоггүй.

Жишээ нь: I've been abroad before.

Энд хилийн чанадад байсан тухай л өгүүлж байна.

I've gotten a letter from Richard.

I got it last week.

Энэ хоёр өгүүлбэрт хоёуланд нь өнгөрсөн үйл явдал үгүйлэгдэж буй боловч нэгдэхэд нь ер нь захиа авсан тухай, хоёрдахид нь хэдийд авсан тухай гарч байна.

Нэгэе талаас энэ 2 жишээнээс үзэхэд одоо өнгөрч буй цаг зөвхөн одоо цагт ойрхон болсон явдал харуулахгүй нь. Учир нь хэрэг дээрээ захиаг өнгөрсөн долоо хоногт авсан байна. Энд гол нь тухайн үйл явдал одоо цагт биелчихсэн, үр дүн нь харагдсан байх ёстой. Үүнээс үзвэл одоо дуусч буй цагийн 2 дахь утга нь тухайн үйл явдлын хэдийд болж өнгөрснийг биш, уг үйл явдал болсон уу, үгүй гэдэг үр дүнг харуулахад оршино.

### Эдийн засгийн англи хэл зааж буй өнөөгийн байдал

МУИС-ийн ЭЗС дээр нийтдээ гурван улирал буюу 272 цаг, дээр нь сонгон суралцах нэг семестр буюу 64 цагт ерөнхий англи хэл, эдийн засгийн англи хэл гэсэн чиглэл нэгдүгээр курсээс эхлэн англи хэлийг үздэг. Манай англи хэлний сургалтанд нэвтрч буй нэг шинэлэг зүйл бол Английн Манчестрийн их сургуулийн туршлагаар сургалтаа блокийн системээр явуулж буй явдал юм. Өөрөөр хэлбэл нэгдүгээр курст элссэн оюутнуудаас хичээлийн жилийн эхний өдөр хэлний мэдлэгийн түвшин тогтоох тест авч мэдлэгийн түвшингээр нь англи хэл огт үзэж байгаагүй, анхны мэдэгдэхүүнтэй, бага зэрэг үзэж байсан, англиар уншиж ойлгох чадвартай гэх мэтээр хувааж ойролцоо түвшний оюутнууд нэг группт суралцах боломж олгодог. Энэ нь багш оюутны аль алинд нь тустай бөгөөд богино хугацаанд шаардлагатай мэдлэг өгөх боломжоор хангадаг.

Хэл огт үзэж байгаагүй буюу эхлэн суралцагсдад англи хэлийг "Headway" гэсэн суралцах бичиг ашиглан заадаг бөгөөд 3 семестрийн турш энэ номын Elementary, pre-intermediate гэсэн 2 дэвтрийг үзэж дуусгадаг. Нийт оюутнууд сонгон суралцах буюу дөрөвдүгээр семестрт эдийн засгийн англи хэлийг 64-хан цагт үзэх нь мэдээж хангалтгүй байдаг. Харин урьд нь англи хэлний зохих мэдлэгтэй элссэн оюутнуудын хувьд шууд эдийн засгийн англи хэл үзэж эхлэх боломжтой байдаг. Эдгээр оюутанд Business objectives, Business opportunities зэрэг суралцах бичгүүдийг 3 семестртээ багтааж үзээд сонгон суралцах шатандаа мэргэжлийн текст, ном зохиол уншиж орчуулах, мэргэжлийн холбогдолтой тайлан реферат бичүүлэх зэргээр нэлээд гүнзгий түвшний мэдлэг олгохуйц хэлбэрээр сургалт явуулдаг.

Манай англи хэлний сургалтын явцад тохиолдож буй бэрхшээлтэй зөрчилтэй тал нь их сургуульд элсэнгүүт англи хэл эхлэн үзэж байгаа оюутнууд ерөнхий англи хэлний анхан шатны мэдлэгтэй болох боловч программын багтаамжаас шалтгаалан эдийн засгийн англи хэлийг зөвхөн сонгон суралцахаар 64 цагт үздэг. Англи хэл сонгоогүй оюутнуудын хувьд үндсэндээ эдийн засгийн англи хэлийг огт үзэхгүй хоцордог.

Дээрхи байдлаас үзэхэд эдийн засгийн англи хэлийг нэгдүгээр курсээс шууд үзэхийн зэрэгцээ нийт мэргэжлийн хэл үзэх сургалтын хугацааг уртасгаж 3 жил буюу 6 семестр болговол эдийн засгийн хэлний мэдлэг эзэмших хангалттай хугацаа

болно гэж бид үзэж байна. Мөн нөгөөтөөгүүр магистрийн түвшинд суралцагсдад энэхүү эдийн засгийн буюу мэргэжлийн англи хэлийг үргэлжлүүлэн үзэхээр тооцсон программ хэрэгжүүлбэл сургалтын үйл явц тасрахгүйгээс гадна мэргэжлийн хэлийг гүнзгийрүүлэн судлах боломжтой болох юм.

### Сурах бичиг, хэрэглэгдэхүүн

Англи хэлний сургалтанд бидний хэрэглэж буй үндсэн сурах бичиг нь дээр өгүүлсэнчилэн Headway номны Elementary, Pre-Intermediate, Business objectives, Business opportunities зэрэг сурах бичгүүд бөгөөд үүний зэрэгцээ Headway (pronunciation), Interchange, Business class, International business зэрэг сурах бичгүүдийг хэрэглэдэг.

Мөн түүнчлэн эдгээр сурах бичгүүдийн хальс хуурцаг, видео бичлэгийн хуурцагууд англи хэлний дүрмийг схемээр үзүүлсэн жишээ, таблиц зэрэг үзүүлэн таниулах материал, гэрийн уншлагад зориулсан хялбаршуулсан текст, богино хэмжээний өгүүлэл, ном зохиол зэрэг нь манай сургалтын үндсэн хэрэглэгдэхүүн болдог.

Ерөнхий англи хэлний мэдлэг олгоход хэрэглэгддэг Headway сурах бичиг нь оюутанд унших, бичих, сонсох, ярих бүх чадварыг эзэмшүүлэхэд зориулсан текст, харилцан яриа, сонсох болон дүрмийн, үгсийн сангийн арвин баялаг дасгалуутайгаас гадна орчин үеийн англи хэл болоод Англи улсын амьдрал ахуй орчинтой оюутныг танилцуулах боломж олгодог сайн сурах бичиг юм. Энэ сурах бичгийн эхний хоёр дэвтрүүг үзсэнээр оюутан англи хэлний үг зүй болон дүрмийн зохих мэдлэгтэй болж ахуйн болоод энгийн сэдвээр унших, ярих боломжтой болно.

Эдийн засгийн англи хэл судлах гол сурах бичиг бол Оксфордын их сургуулиас хэвлүүлсэн **Business objectives** гэсэн шинэ сурах бичиг юм. Энэ сурах бичиг нь агуулгын хувьд бизнесийн салбарт хүнтэй танилцах, утсаар болон факсаар харилцах, эрхэлж буй ажил, пүүс компания танилцуулах, мэдээлэл солилцох, уулзалт ярилцлага зохиох, гэрээ хэлэлцээр байгуулах, бизнесийн ололт амжилтаа тоон хэллэг, схем диаграммаар харуулах, аялал жуучлал зэрэг бизнесийн үйл ажиллагаатай холбогдсон өргөн сэдвийг хамарснаараа мэргэжлийн мэдлэг олгох, танин мэдэхүйн чухал ач холбогдолтой.

Дээрхи сэдэв бүрээр дүрэм, сонгол болон үгсийн сангийн дасгалууд өгөгдсөн байх бөгөөд сурах бичгийн арталд оюутны бие даасан ажиллагаанд зориулагдсан нэмэлт мэдээлэл өгөгдсөний зэрэгцээ үйл үгийн цаг, баймж үйл үг, нэр үг, тэмдэг нэр, тооны нэр, нөхцөлт төлөвийг хэрхэн хэрэглэх тухай дүрмийн тайлбар, дүрэм бус үйл үгийн жагсаалт, эдийн засгийн нэр томъёо зэргийг хавсаргасан байдаг.

Энэ сурах бичгийн нэг дутагдалтай тал нь сонсох чадвар дадалд зориулагдсан дасгал ажлууд их хэмжээгээр орсон боловч оюутнууд олж авсан мэдлэгээ хэрэгжүүлэхийн тулд бие дааж хийх дасгал харьцангуй багатайн дээр сонирхол

татахуйц бус, нэг хэв загварын дасгалууд давтагдаж орсон байдаг.

Мэргэжлийн хэл эзэмшихэд нэн тэргүүн шаардлагатай гэж бидний үзэж буй унших, ярих, ойлгох, санаагаа илэрхийлэх зэрэг чадваруудыг нэгэн зэрэг өгөх боломжтойн сацуу дүрмийн зохих ойлголт өгдөг хялбаршуулсан текст ховор байдаг нь хамгийн том дутагдал юм. Мөн Headway сурах бичгээс зохих хэмжээний дүрмийн мэдлэг олж авсан оюутнуудад Business objectives сурах бичгийн дүрэм дэндүү хялбар бөгөөд урьд үзсэнээ дахин давтаж үзэх болдог.

### Ашигласан материал

1. Teaching oral English. Donn Byrne Longman.
2. The practice of English language teaching. Jeremy Harmer Longman.
3. Teaching and learning grammar Jeremy Harmer Longman.
4. Teaching English writing Anita Pincas ELTS.
5. Reading in the language class room. Eddie Williams ELTS.
6. A rapid course in English for student of Economics Oxford University Press.
7. Business reports in English Cambridge University Press.
8. Е.И.Мотина. Язык и специальность: лингво-методические основы обучения русскому языку студентов-нефилологов. М., 1988.
9. Русский язык для студентов иностранцев. Сборник методических статей. Том 19, 22. Москва, 1980.
10. Вопросы психолингвистики и преподавания русского языка как иностранного. Москва, 1971.
11. Д. И. Изаренков. Обучение диалогической речи. Москва, 1981.
12. Иностранные языки в высшей школе. Выпуск 1. Москва, 1981.